| Мөнгөн хөрөнгө | 56,845.7 | 02.8 | 47,392.7 | 02.4 | (9,453.0) | (16.6) |
| Авлага | 119,469.7 | 05.8 | 177,366.0 | 09.0 | 57,896.3 | 48.5 |
| Бараа материал | 115,353.8 | 100.0 | 104,339.6 | 05.3 | (11,014.3) | (9.6) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,761,724.3 | 85.8 | 1,635,688.6 | 83.3 | (126,035.8) | (7.15) |
| Үндсэн хөрөнгө | 2,422,529.2 | 118.0 | 2,358,656.0 | 120.0 | (63,873.3) | (2.6) |
| Хуримтлагдсан элэгдэл | (660,804.9) | (32.2) | (722,967.4) | (36.8) | (62,162.5) | 9.4 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 2,053,393.6 | 100.0 | 1,964,786.8 | 100.0 | (88,606.7) | (4.3) |
| Өр төлбөр | 914.4 | 00.0 | 4,416.7 | 00.2 | 3,502.4 | 383.0 |
| Засгийн газрын хувь оролцоо | 2,052,479.2 | 100.0 | 1,960,370.1 | 99.8 | (92,109.1) | (4.5) |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,053,393.6 | 100.0 | 1,964,786.8 | 100.0 | (88,606.7) | (4.3) |

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 47,392.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 9,453.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 177,366.0 мянган төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага байна.

Төсвийн худалдан авалтаар 182,431.7 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 154.0 мянган төгрөгийн барааг Эрүүл мэндийн газраас шилжүүлэн авсан бөгөөд нийт 193,599.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, эцсийн үлдэгдэл 104,339.6 мянган төгрөгийн бараа материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,358,656.0 мянган төгрөг болж 63,873.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 7,810.4 мянга, аймгийн Эрүүл мэндийн газраас 4,301.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 7/42 дугаар тогтоолоор 74,784.7 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг актлах шийдвэр гарсны дагуу данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/61 дугаар тогтоолоор 1,200.0 мянган төгрөгийн 600 м.кв газрыг сумын Засаг даргын Тамгын газарт балансаас балансад шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,416.7 мянган төгрөг болж өмнөх оноос 3,502.4 төгрөгөөр буурсан нь орон нутгийн төсвийн санхүүжилт дутуу орсонтой холбоотой түлш, халаалтын өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,960,370.1 мянган төгрөг болж 92,109.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үр дүн рүү өмнөх оны өглөгтэй холбоотой 1,200.0 мянга, тайлант үеийн үр дүнгийн (90,909.1) мянган төгрөгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,112,168.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,318,123.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 45,214.1 мянган төгрөгөөр бууруулж 1,272,909.7 мянган төгрөгөөр баталсан бөгөөд оны эцэст тодотголоор 1,373,756.2 мянган төгрөг болгон нэмэгдүүлж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1,373,756.2 мянга, орон нутгийн төсвөөс 178,684.4 мянга төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,551,477.1 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 963.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,289,833.0 мянган төгрөг буюу 83.1 хувьтай байгаа нь байр цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 165,407.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 18,565.8 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 963.5 мянга, хангамж бараа материалын зардал 13,312.8 мянга, нормативт зардал 56,575.6 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 3,248.5 мянга, томилолт зочны зардал 1,350.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,183.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,999.8 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ | |
|-----|---|--------------|--------------|--------------------|---------|
| | | | | Зөрүү | Биелэлт |
| 1 | 80302 Нэг иргэнд ногдох нормативаар | 1,018,220.10 | 854,676.10 | 163,544.00 | 83.94 |
| 2 | 81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 235,204.20 | 160,500.10 | 74,704.10 | 68.24 |
| 3 | 83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан | 120,331.90 | 96,935.89 | 23,396.01 | 80.56 |
| 4 | 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 178,684.40 | 177,720.89 | 963.51 | 99.46 |
| | Нийт дүн | 1,552,440.60 | 1,289,832.98 | 262,607.62 | 83.08 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Судалгаа 1. Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Судалгаа 2. Тус байгууллага нь хоолны хөнгөлөлт нэг өдөр 5.0 мянган төгрөгөөр тооцож хоолны хөнгөлөлтөд 47,265.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 38,937.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Судалгаа 7. Бүтэц орон тоог Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар 30 орон тоог баталсан бөгөөд жилийн эцсийн байдлаар цалингийн зардалд 810,255.8 мянган төгрөг, 27 орон тоо ажиллаж, их эмчийн 2, эм зүйчийн 1 орон тоо хасагдсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд “РМВ” ХХК-иас 139,984.4 мянган төгрөгийн дулаанаар хангах гэрээ, “НИК” ХХК-тай газрын тосны бүтээгдэхүүн зээлээр нийлүүлэх гэрээ тус тус байгуулж, 25,000.0 мянган төгрөгийн барилга засварын материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бэлтгэн нийлүүлэгчтэй шууд худалдан авалт хийж гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Сармандах, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Мөнхтуяа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 1,316,910.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,169.1 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 8,559.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 194 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 189 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 176,914.8 мянган төгрөгийн 13 гүйлгээ

мэдээлэхээс 163,833.5 мянган төгрөгийн зарлагыг мэдээлж, 13,081.3 мянган төгрөгийн 1 гүйлгээг аудитын явцад нөхөн мэдээлүүлж, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 164,984.4 мянган төгрөгийн 64 мэдээллийг бүрэн байршуулсан ба цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,254,549.3 мянган төгрөгийн 35 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитаар 40,000.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэн бөгөөд жилийн эцсийн аудитаар алдаа, зөрчил арилаагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитаар 11,479.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 4,925.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 56 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------|---------|----------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 11,479.3 | 2 | 11,479.3 | 100% |
| Төлбөрийн акт | 2 | 4,925.7 | 2 | 4,925.7 | 100% |
| Нийт дүн | 4 | 16,405.0 | 4 | 16,405.0 | 100% |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40,000.0 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэнд цаашид давтан гаргахгүй байх зөрчлийг арилгах 3 албан шаардлага өгсөн.

Аудитаар илэрсэн худалдан авах ажиллагааны 25,000.0 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн “Үнэн ба зөв байх” батлам мэдэгдлийг хангаагүй ба бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 16,440.1 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант онд 25,000.0 мянган төгрөгөөр барилга засварын материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр 20,000.0 мянган төгрөгөөс дээш өртөгтэй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулахгүй шууд худалдан авалт хийдэг байдлыг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.1.2 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 15,000.0 мянган төгрөгийг "Хөх хотод" ажилчдыг үзлэг шинжилгээнд хамруулахад зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоож, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.1.3 Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй (3 төрлийн) 7,576 м.кв газрын мэдээллийг газар эзэмших эрхийн гэрчилгээ болон газрын цахим (egazar.gov.mn) сантай тулган шалгахад үндсэн хөрөнгийн бүртгэлээс 1,197 м.кв-аар их зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 15,000.0 мянган төгрөгийг "Хөх хотод" ажилчдыг үзлэг шинжилгээнд хамруулахад зарцуулсан байна. | 1 | 15,000.0 | | | 1 | 15,000.0 | | |
| Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй (3 төрлийн) 7,576 м.кв газрын мэдээллийг газар эзэмших эрхийн гэрчилгээ болон газрын цахим (egazar.gov.mn) сантай тулган шалгахад үндсэн хөрөнгийн бүртгэлээс 1,197 м.кв-р их зөрүүтэй байна. | 1 | - | | | 1 | - | | |
| Нийт дүн | 2 | 15,000.0 | | | 2 | 15,000.0 | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд 25,000.0 мянган төгрөгөөр барилга засварын материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | 25,000.0 | | | 1 | 25,000.0 | | |
| Дүн | 1 | 25,000.0 | | | 1 | 25,000.0 | | |

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 3/ 10571284/БНА-2026/
127/НА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 25,000,000 (Хорин таван сая) төгрөгөөр барилга засварын материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

8426090010

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Төсвийн хөрөнгөөр 25,000,000 (Хорин таван сая) төгрөгөөс дээш өртөгтэй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулахгүй шууд худалдан авалт хийдэг байдлыг таслан зогсоож, зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЭМТ-ийн дарга Д.Сармандах, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Г.ЭНХЗУЛ* Б.МӨНХБАТ

АУДИТОР

Г.ЭНХЗУЛ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 08/A0571284/БНА-2026/
127/НА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 15,000,000 (арван таван сая) төгрөгийг "Хөх хотод" ажилчдыг үзлэг шинжилгээнд хамруулахад зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

8426090022

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоож, нотлох баримтыг 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЭМТ-ийн дарга Д.Сармандах, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР

Г.ЭНХЗУЛ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 9/ А0571284 / БНА-2026/ Номгон
127/ НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй (3 төрлийн) 7,576 м.кв газрын мэдээллийг газар эзэмших эрхийн гэрчилгээ болон газрын цахим (egazar.gov.mn) сантай тулган шалгахад үндсэн хөрөнгийн бүртгэлээс 1,197 м.кв-аар их зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, зөрчил арилгаж, нотлох баримтыг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

6426090026

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЭМТ-ийн дарга Д.Сармандах, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

АУДИТОР

Г.ЭНХЗУЛ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно